



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 51

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18,838,470.71 /арван найман сая найман зуун гучин найман мянга дөрвөн зуун далан төгрөг далан нэгэн мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 1,412,885.16 /нэг сая дөрвөн зуун арван хоёр мянга найман зуун наян таван төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Бага сургуулийн барилгыг доорх газрын хамт Луус сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2 Луус сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Ганчимэг), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Долгоржав) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн
51 дүгээр тогтоолын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Тоошир хэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Бага сургуулийн барилга	1940	м2	254	1	18,838,470.41	1,412,885.18	17,425,585.23
Дүн						18,838,470.71 /арван найман сая найман зуун гучин найман мянга дөрвөн зуун далан төгрөг далан нэгэн мөнгө/ төгрөг	1,412,885.16 /нэг сая дөрвөн зуун арван хоёр мянга найман зуун наян таван төгрөг арван зургаан мөнгө/ төгрөг	17,425,585.23 /арван долоон сая дөрвөн зуун хорин таван мянга таван зуун наян таван төгрөг хорин гурван мөнгө/ төгрөг